



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

А.Мөнхцэцэг

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.1 Зөвлөмж.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 79

танай _____-ны № _____-т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,873,266.79</u>	<u>89,774,818.42</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,450,722.57
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	3,450,722.57
3121	Төгрөг	00.00	3,450,722.57
31211	Төрийн сангийн харилцах	00.00	297,521.21
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	3,153,201.36
33	АВЛАГА	00.00	34,718,700.00
335	Бусад авлага	00.00	34,718,700.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	34,718,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,873,266.79	51,605,395.85
351	Түүхий эд материал	16,973,416.79	35,598,099.67
35110	Тусгай зориулалттай материал	10,582,269.49	14,060,623.72
35130	Эм боох материал	6,391,147.30	21,537,475.95
354	Хангамжийн материал	18,234,850.00	15,132,296.18
35410	Бичиг хэргийн материал	1,591,750.00	1,424,750.00
35420	Аж ахуйн материал	14,624,420.00	8,475,400.00
35440	Түлш, шатах тослох материал	483,940.00	448,549.18
35460	Хүнсний материал	1,534,740.00	4,783,597.00
35600	Мал амьтад	665,000.00	875,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>323,419,926.01</u>	<u>339,239,311.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	323,419,926.01	339,239,311.44
392	Биет хөрөнгө	308,019,926.01	323,839,311.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	258,094,390.00	258,094,390.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,700,588.48	-31,785,732.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,200,000.00	58,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,266,666.66	-36,800,000.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,049,013.52	130,679,881.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,098,986.33	-79,990,026.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,742,400.00	31,424,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,986,304.22	-13,275,875.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,889,858.00	13,889,858.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,903,189.82	-6,597,682.74
393	Биет бус хөрөнгө	15,400,000.00	15,400,000.00
39301	Програм хангамж	1,020,000.00	1,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,020,000.00	-1,020,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,400,000.00	15,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>359,293,192.80</u>	<u>429,014,129.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>3,144,779.03</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,144,779.03
413	Өглөг	00.00	3,144,779.03
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,447,488.03
4136	Бусад өглөг	00.00	697,291.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	697,291.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>359,293,192.80</u>	<u>425,869,350.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	359,293,192.80	425,869,350.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,702,619.72	429,702,619.72
51101	Өмч: - төрийн	429,702,619.72	429,702,619.72
512	Хуримтлагдсан үр дүн	-99,221,028.00	-32,644,869.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-99,221,028.00	-99,221,028.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	66,576,158.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,811,601.08	28,811,601.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>359,293,192.80</u>	<u>429,014,129.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,914,742.00	746,333,769.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,583,336.00	57,172,093.79
120	Нийтлэг татварын бус орлого	7,583,336.00	57,172,093.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,583,336.00	57,172,093.79
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	14,797,367.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,583,336.00	42,374,726.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,985,906.00	307,657,576.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	375,345,500.00	381,504,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,020,846.00	233,227,546.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,741,146.00	228,867,546.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	279,700.00	4,360,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,694,900.00	18,407,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,694,900.00	18,407,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,270,160.00	56,022,730.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,270,160.00	56,022,730.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	458,593,419.83	679,757,611.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,593,419.83	679,757,611.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,491,152.83	651,645,111.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,998,858.00	328,024,689.46
210101	Үндсэн цалин	158,632,985.00	231,001,319.60
210102	Нэмэгдэл	68,373,509.00	71,800,650.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,299,872.00
210104	Урамшуулал	44,992,364.00	18,922,846.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,379,400.00	44,608,861.00
210201	Тэтгэврийн даатгал	27,711,500.00	33,114,061.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,917,000.00	2,873,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,333,600.00	2,299,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583,300.00	574,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,834,000.00	5,747,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,923,360.00	14,139,981.82
210301	Гэрэл, цахилгаан	3,704,564.00	3,583,055.00
210302	Түлш, халаалт	9,218,796.00	10,556,926.82
2104	Хангамж, бараа материалын зардал	24,169,685.56	34,157,080.00
210401	Бичиг хэрэг	2,530,800.00	4,644,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,390,290.00	16,495,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,271,860.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,222,300.00	850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,255,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,826,295.56	9,641,020.00
2105	Нормативт зардал	47,517,495.30	169,979,370.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,559,555.30	147,342,702.35
210502	Хоол, хүнс	10,957,940.00	21,056,668.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,580,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,500.00	10,345,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,500.00	20,000.00
210604	Урсгал засвар	00.00	10,325,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,005,700.00	383,400.00
210702	Дотоод албан томилолт	1,005,700.00	383,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,061,666.00	16,250,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,061,666.00	16,250,047.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,397,487.97	33,756,682.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,641,910.00	4,263,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	30,755,577.97	29,493,582.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,102,267.00	28,112,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,387,863.00	28,112,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,387,863.00	28,112,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,714,404.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,678,677.83	66,576,158.03
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-25,678,677.83	66,576,158.03

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	-76,531,206.85	00.00	357,118,414.03
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,702,619.72	3,947,001.16	-76,531,206.85	00.00	357,118,414.03
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,853,456.60	00.00	27,853,456.60
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	28,811,601.08	-99,221,028.00	00.00	359,293,192.80
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	28,811,601.08	-99,221,028.00	00.00	359,293,192.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,702,619.72	28,811,601.08	-99,221,028.00	00.00	359,293,192.80
D04	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	66,576,158.03	00.00	66,576,158.03
D05	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,702,619.72	28,811,601.08	-32,644,869.97	00.00	425,869,350.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	426,251,033.00	654,442,976.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,251,033.00	654,442,976.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	375,345,500.00	381,504,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,940,473.00	233,227,546.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	919,627.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,741,146.00	228,867,546.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	279,700.00	4,360,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,694,900.00	18,407,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,694,900.00	18,407,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,270,160.00	21,304,030.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,270,160.00	21,304,030.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	419,811,633.00	620,476,653.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,811,633.00	620,476,653.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,709,366.00	592,364,153.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,775,696.00	325,771,201.43
210101	Үндсэн цалин	157,409,823.00	228,747,831.57
210102	Нэмэгдэл	68,373,509.00	71,800,650.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,299,872.00
210104	Урамшуулал	44,992,364.00	18,922,846.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,379,400.00	44,608,861.00
210201	Тэтгэврийн даатгал	27,711,500.00	33,114,061.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,917,000.00	2,873,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,333,600.00	2,299,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583,300.00	574,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,834,000.00	5,747,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,704,564.00	3,583,055.00
210302	Түлш, халаалт	9,702,736.00	9,824,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,090,190.00	24,199,060.00
210401	Бичиг хэрэг	2,499,900.00	4,477,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,390,290.00	16,495,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,271,860.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,255,000.00
2105	Нормативт зардал	37,955,842.00	151,403,484.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,955,922.00	123,281,959.00
210502	Хоол, хүнс	10,799,920.00	24,305,525.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	3,816,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,518,500.00	12,848,700.00

**Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,518,500.00	1,863,700.00
210602	Тавилга	00.00	660,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	10,325,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,005,700.00	383,400.00
210702	Дотоод албан томиллолт	1,005,700.00	383,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,934,828.00	16,144,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,934,828.00	16,144,047.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,641,910.00	3,598,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,641,910.00	3,598,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,102,267.00	28,112,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,387,863.00	28,112,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,387,863.00	28,112,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,714,404.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,439,400.00	33,966,322.57
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,439,400.00	30,515,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,439,400.00	30,515,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,439,400.00	30,515,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,439,400.00	30,515,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,439,400.00	-30,515,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,450,722.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,450,722.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	434,877,400.00	420,917,908.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,877,400.00	420,917,908.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,377,400.00	419,517,408.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,372,200.00	280,114,026.79
210101	Үндсэн цалин	185,828,200.00	183,090,656.93
210102	Нэмэгдэл	72,000,000.00	71,800,650.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	6,299,872.00
210104	Урамшуулал	20,000,000.00	18,922,846.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,795,200.00	38,795,200.00
210201	Тэтгэврийн даатгал	27,300,400.00	27,300,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,873,700.00	2,873,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,299,000.00	2,299,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	574,700.00	574,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,747,400.00	5,747,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,407,300.00	13,407,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,407,300.00	3,583,055.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	9,824,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,950,000.00	18,597,860.00
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	2,226,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,400,000.00	14,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,271,860.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,400,000.00	700,000.00
2105	Нормативт зардал	36,382,700.00	34,596,075.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,582,700.00	22,855,950.00
210502	Хоол, хүнс	10,800,000.00	9,790,125.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	12,930,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	3,447,700.00
210602	Тавилга	5,000,000.00	4,483,100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	334,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,000,000.00	334,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,870,000.00	17,144,047.00

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,870,000.00	17,144,047.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3600000.00	3598100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	3,598,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	1400500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,400,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,400,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	421,215,430.00	421,215,430.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	381,504,100.00	381,504,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381,504,100.00	381,504,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,407,300.00	18,407,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	18,407,300.00	18,407,300.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,304,030.00	21,304,030.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,304,030.00	21,304,030.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	297,521.21
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	7	7
620004	Гэрээт ажилтан	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	230,074,344.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,074,344.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,362,344.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,657,174.64
210101	Үндсэн цалин	45,657,174.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,813,661.00
210201	Тэтгэврийн даатгал	5,813,661.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,601,200.00
210401	Бичиг хэрэг	2,251,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,095,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,255,000.00
2105	Нормативт зардал	116,807,409.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,426,009.00
210502	Хоол, хүнс	14,515,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,866,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,433,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,219,500.00
210602	Тавилга	3,889,000.00
210604	Урсгал засвар	5,325,000.00
2107	Томилолт, зочны зардал	49,400.00
210702	Дотоод албан томилолт	49,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26712000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,712,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	233227546.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,227,546.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,867,546.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,360,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны СБА-2022/85/НА-СТА-ТШЗ

дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлж ажиллана” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 432.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69.7 сая төгрөг буюу 19.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	3.4	3.4
Авлага	0.00	34.7	34.7
Бараа материал	35.8	51.6	15.8
Үндсэн хөрөнгө	323.4	339.2	15.8
Нийт хөрөнгө	359.3	429.0	69.7
Өр төлбөр		3.1	3.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	359.3	425.9	66.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	359.3	429.0	69.7

Авлага дансны үлдэгдэл 34.7 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгогдоогүй нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 51.6 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь Коронавирус цар тахлын хүрээнд эмнэлгийн халдвар хамгаалал, нэг удаагийн хэрэгсэл худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 339.2 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр өсжээ. Энэ нь Коронавирус цар тахлын хүрээнд дээд шатын төсөв захирагч, бусад газраас 14.8 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь гол нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 429.0 сая төгрөг болж 69.7 сая төгрөгөөр өссөн байна.

Түвшинширээ сумын хүн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 313.4 сая төгрөг буюу 72.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох болон нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 34.7 сая төгрөгөөр өссөн, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 29.7

сая, нэмэлт санхүүжилтийн орлого 225.2 сая, төсвийн урсгал санхүүжилт 8.8 сая төгрөг болж өссөн нь үр дүнгийн тайлангийн орлого өсөхөд гол нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 221.1 сая төгрөг буюу 48.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг зардлууд өссөн нөлөөлсөн байна. Энэ нь ковид19 цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагаар ажилласан ажлын хөлс, хэвтэн эмчлүүлсэн иргэдийн эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд 421.2 сая төгрөгийн төсөв баталснаас 381.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 18.4 сая төгрөгийн орон нутгийн төсвөөс, 21.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 381.5 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 18.4 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 21.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 420.9 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 228.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.4 сая, нийт 233.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 45.6, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5.8, хангамж, бараа материалын зардал 5.6 сая, норматив зардал 116.8, эд хогшил худалдан авах 29.4, томилолт 0.1, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 26.7, нийт 230.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 3.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин

дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тайлант онд Түвшинширээ сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг төлөвлөж, төсвийн гүйцэтгэл 90 хувийн биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 зарлагын гүйлгээний 122.5 сая, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээний 591.2 сая төгрөгийг хугацаа хоцроож мэдээлсэн тул зөвлөмж хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 зөвлөмж, зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	2.9	2	2.9	-	-	-
Албан шаардлага	1	1.1	1	1.1	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	4	4.0	4	4.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Эрүүл мэндийн төвийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн данс, үндсэн хөрөнгийн зардалтай холбоотой нийт 2 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 97 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 713.7 сая төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түвшинширээ сумын Хүн эмнэлэг	2	-	-	-	-	-	-	-	2	-